


АЛХАМ 1:

Төрийн цахим үйлчилгээний “E-Mongolia” системд ДАН гаар баталгаажуулж нэвтэрнэ.


Нэвтрээд орсоны дараа доош гүйлгэхээр сурталчилгааны хөдөлгөөнт дүрстэй 7 баннер солигдож байгаа. Эдгээрээс 2 дахь баннер дээр дарна.

Доор зургаар харуулсан зураг бүхий баннер харагдана гэсэн үг.



АЛХАМ 2:

Дээрх баннер дээр дарангуут энэ зурагт харуулсан анхааруулга гарч ирнэ. Зөвшөөрөх товчийг дарна.



АЛХАМ 3:

Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогын асуулга нээгдэнэ. Асуулга нь дараах 4 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- I. ХАЯГИЙН ХЭСЭГ
- II. ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ
- III. ӨРХИЙН АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ
- IV. ХҮН АМЫН АСУУЛГА

Иргэн асуулгыг дараах байдлаар бөглөнө. Нэвтэрч орсон иргэн ТАНЫ төрд байгаа мэдээллээр хаягийн хэсгийн бүх үзүүлэлт нөхөгдсөнөөр цонхонд харагдана. Төрд байгаа мэдээллээ баталгаажуулах үүрэгтэй учраас мэдээллээ үнэн зөв болгож бөглөхийг **анхаарна уу**. Ингэхдээ албан ёсны бүртгэлтэй баримт бичигт таны мэдээлэл ямар байдлаар байгаагаа өөрийгөө баталж бөглөх нь чухал юм.

ТООЛЛОГЫН ТУХАЙ

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2025 ОНЫ ЗАВСРЫН ТООЛЛОГО

(Монгол Улсын "Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай" хуулийн 18 дугаар зүйл, "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт тус тус заасны дагуу өрх, хүн бүрийн мэдээллийн нууцыг чандлан хадгална.)

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

II. ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

III. ӨРХИЙН АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ

IV. ХҮН АМЫН АСУУЛГА

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

(Одоогийн амьдарч байгаа хаягийн мэдээллийг бөглөнө.)

2. Аймаг, нийслэл: *

Улаанбаатар

3. Сум, дүүрэг: *

Сүхбаатар

АНХААРАХ АСУУЛТУУД:

Хаягийн хэсгийн 16 дугаар асуулт нь өрхийн хэлбэрийг асууна. Энэ асуултад хариулахдаа дараах тодорхойлолтыг уншиж бөглөнө.

16. Өрхийн хэлбэр: *

☒ Үндсэн өрх

☐ Хамт суугаа өрх

Үндсэн өрх гэдэг нь сууцны төрөл, хэлбэрээс үл хамааран тухайн сууцыг өмчлөгч өрх, сууц эзэмших эрхийн бичиг (ордер), орон сууц хөлслөх гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа өрх, эсвэл өмчлөгч нь өөр этгээд боловч уг сууцанд хамгийн удаан хугацаагаар амьдарч байгаа өрхийг хэлнэ.

Хамт суугаа өрх гэдэг нь тухайн хаягт амьдарч байгаа боловч өрхийн сууц нь өөрийн эзэмшил биш, тухайн сууц эзэмшигчтэй хамт суудаг өрхийг хамруулна.

17 дугаар асуулт өрхийн гишүүдийн тоо бөглөгдсөн байгаа. Та өрхийн гишүүдийн тоогоо нягталж, хэрэв зөрүүтэй байвал засаж оруулна. Хаягийн хэсэгт нийт 19 асуулт байгааг бүрэн нөхөж дууссаны дараа **ДАРААГИЙН ХУУДАС** руу шилжинэ.

II. ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

II. ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

1. Танайх ямар төрлийн сууцанд суудаг вэ?  *

☒ Байшин: Орон сууцны байшин

☐ Байшин: Бие даасан тохилог сууц

☐ Байшин: Нийтийн байр

☐ Бусад сууц

Талбайн хэмжээ  *

58

2. Танай сууцны цахилгааны эх үүсвэр юу вэ?  *

☒ Төвлөрсөн систем

Энэ бүлэг нь нийт 9 асуулттай. Мөн дээрх зарчмаар таны мэдээлэл бөглөгдсөн хэлбэртэй харагдана. Та асуултуудаа сайтар уншаад асуултаа ойлгохгүй байвал асуултын тэмдэгний ард байгаа цэнхэр товч дээр дарахаар асуултын ойлголт, тодорхойлолт гарч ирнэ.

Бөглөж дуусаад дараагийн хэсэг рүү шилжинэ.

III. ӨРХИЙН АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ

Энэ бүлэг 5 асуулттай.

III. ӨРХИЙН АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТ

12. Мал, тэжээвэр амьтантай эсэх

(Мал, тэжээвэр амьтад гэж хөдөө аж ахуйн зориулалтаар өсгөн үржүүлж байгаа амьтдыг хамруулна. Үүнд: адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа болон гахай, шувуу, зөгийн аж ахуй орно. Ашиг олох зорилгогүйгээр өсгөн үржүүлж байгаа гэрийн тэжээмэл амьтад (муур, нохой зэрэг) нь энд хамаарахгүй.) *

☐ Тийм

☒ Үгүй

14. Газар тариалан эрхэлдэг эсэх *

☐ Тийм

☒ Үгүй

IV. ХҮН АМЫН АСУУЛГА

Эхний 3 хэсгийн асуулгыг бүрэн нөхсөний дараа хүн амын асуулгыг та бөглөнө. Өрхийн гишүүдийн тоогоор хүн амын асуулга нээгдэнэ. Дараах байдлаар цонхонд харагдана.

Энэ цонхонд харуулсан 6 гишүүн жишээ болно.

IV. ХҮН АМЫН АСУУЛГА

IV. ХҮН АМЫН АСУУЛГА *

1-р гишүүн

2-р гишүүн

3-р гишүүн

4-р гишүүн

5-р гишүүн

6-р гишүүн

1-р гишүүн

17. Ургийн овог *

БОРЖИГОН

18. Эцэг, эхийн нэр *

19. Өөрийн нэр *

20. Регистрийн дугаар *

-- -- #####

Өөрийн хувийн мэдээллээ та баталгаажуулж нийт 50 асуултад та бүрэн хариулсан байх ёстой. Үүний дараа өрхийн дараагийн гишүүдийн мэдээллийг та бөглөнө. Ингэхдээ өрхийн гишүүдийн регистрийн дугааруудыг бүрэн мэдэж байх ёстой. Өрхийнхөө бүх гишүүдийн мэдээллийг бүрэн бөглөөд дуусгах товчийг дарсанаар асуулгад бүрэн хариулсан гэж үзнэ.